



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 48

Мандалговь

Г Хөрөнгө данснаас хасах тухай Г

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 19,600,000 /арван есөн сая зургаан зуун мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, 272,222 /хоёр зуун далан хоёр мянга хоёр зуун хорин хоёр/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Дуа 99-22 улсын дугаартай Уаз-15192 маркыг автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 3,000,000 /гурван сая/ тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Хорлоод даалгасугай.

ДАРГА



С.СҮХБААТАР